**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

# ХЭНТИЙ АЙМГИЙН ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: ХЭА-2025/047/НА-СТА-ТШЗ**

Чингис хот 2025 он
Цахим хуудас: www.open.audit.mn

**Тэргүүлэх аудитор:** Ж.Ганбаатар
Утас: 70562112
Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390
Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Х.Еркегүл
Утас: 99040705
Цахим хаяг: erkhegulkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас.70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.24 № 191

танай ______________ -ны № ______________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ү.ИЧИНХОРЛОО ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд орон нутгийн төсвөөс 1,306,027.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтээр 5,034.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, гүйцэтгэлээр 1,265,463.0 мянган төгрөгийг зарцуулж, 57,349.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд төрийн захиргааны албан тушаалд тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад мөнгөн урамшуулал олгож эхэлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитаар мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, цалингийн зардлыг аудитын чиглэл болгон чухалчлан авч үзэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 100,766.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу бүртгэсэн 76,104.0 мянган төгрөг, урьдчилж төлсөн зардлыг бүртгээгүй 7,500.0 мянган төгрөг, хөрөнгийн ангилал сольж бүртгэсэн 4,000.0 мянган төгрөг, нийт 90,604.0 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулав.

232502191

Төрийн захиргааны албан тушаалд томилогдон тасралтгүй ажилласан албан хаагчид олгох мөнгөн урамшууллаас 2,835.6 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаж төсөвт төвлөрүүлээгүй, ажилласан хугацаа нь 5 жил хүрээгүй 1 ажилтанд 7,326.7 мянган төгрөг олгосон зөрчилд 2 төлбөрийн акт тогтоов.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 81 зорилтын хүрээнд 118 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, хэрэгжилт 89.7 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшниих боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **124,822,135.25** | **166,920,422.38** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 34,800.00 | 133,600.00 |
| 312 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 34,800.00 | 133,600.00 |
| 3121 | **Төгрөг** | 34,800.00 | 133,600.00 |
| **31214** | Бусад төсөл, нөөцийн харилцах | 34,800.00 | 133,600.00 |
| 33 | **АВЛАГА** | 75,005.25 | 622,522.38 |
| **33100** | Ажиллагчидтай холбогдсон авлага | 75,005.25 | 622,522.38 |
| 34 | **УРЬДЧИЛГАА** | 14,000,000.00 | 21,500,000.00 |
| 3471 | **Урьдчилгаа тооцоо** | 14,000,000.00 | 21,500,000.00 |
| **34712** | Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | 14,000,000.00 | 21,500,000.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 110,712,330.00 | 144,664,300.00 |
| 351 | **Түүхий эд материал** | 3,654,000.00 | 7,654,000.00 |
| **35110** | Тусгай зориулалттай материал | 3,654,000.00 | 7,654,000.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 75,506,830.00 | 90,428,800.00 |
| **35410** | Бичиг хэргийн материал | 370,000.00 | 816,000.00 |
| **35420** | Аж ахуйн материал | 11,760,630.00 | 16,691,130.00 |
| **35440** | Түлш, шатах тослох материал | 332,500.00 | 3,499,100.00 |
| **35450** | Барилгын засварын материал | 1,056,000.00 | - |
| **35470** | Бусад хангамжийн материал | 61,987,700.00 | 69,422,570.00 |
| **35600** | Мал амьтад | 31,551,500.00 | 46,581,500.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,888,190,608.35** | **6,662,213,034.62** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,888,190,608.35 | 6,662,213,034.62 |
| 392 | **Биет хөрөнгө** | 2,448,612,608.35 | 6,222,635,034.62 |
| **39201** | Барилга, байгууламж, орон сууц | 2,542,837,430.00 | 6,295,251,451.00 |
| **39202** | Хуримтлагдсан элэгдэл | (564,404,904.88) | (713,836,329.50) |
| **39203** | Авто-тээврийн хэрэгсэл | 383,039,800.00 | 558,255,000.00 |
| **39204** | Хуримтлагдсан элэгдэл | (197,251,952.61) | (212,758,152.71) |
| **39205** | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 329,056,801.80 | 407,631,701.80 |
| **39206** | Хуримтлагдсан элэгдэл | (156,292,267.07) | (210,010,594.54) |
| **39207** | Тавилга, аж ахуйн эд хогшил | 153,535,560.45 | 180,535,560.45 |
| **39208** | Хуримтлагдсан элэгдэл | (66,035,997.30) | (84,460,920.43) |
| **39209** | Зам, гүүрийн байгууламж | 453,468,800.00 | 453,468,800.00 |
| **39210** | Хуримтлагдсан элэгдэл | (429,340,662.04) | (451,441,481.45) |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 439,578,000.00 | 439,578,000.00 |
| **39303** | Бусад биет бус хөрөнгө | 439,578,000.00 | 439,578,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,013,012,743.60** | **6,829,133,457.00** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,013,012,743.60** | **6,829,133,457.00** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,013,012,743.60 | 6,829,133,457.00 |
| **511** | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,601,661,368.17 | 1,601,661,368.17 |
| **51101** | Өмч: - төрийн | 1,601,661,368.17 | 1,601,661,368.17 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 1,367,832,382.79 | 5,183,953,096.19 |
| **51210** | Өмнөх үеийн үр дүн | 1,367,832,382.79 | 1,367,832,382.79 |
| **51220** | Тайлант үеийн үр дүн | - | 3,816,120,713.40 |
| **51300** | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 43,518,992.64 | 43,518,992.64 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,013,012,743.60** | **6,829,133,457.00** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,086,676,927.00** | **5,334,295,814.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **260,858,000.00** | **4,023,234,021.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 260,858,000.00 | 4,023,234,021.00 |
| **120004** | Төсөв байгууллагын өөрийн орлого | 257,858,000.00 | 4,018,234,021.00 |
| **1200042** | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 200,000.00 | - |
| **1200045** | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 257,658,000.00 | 4,018,234,021.00 |
| **120009** | Бусад орлого | 3,000,000.00 | 5,000,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **825,818,927.00** | **1,311,061,793.00** |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 51,934,527.00 | 5,034,193.00 |
| **131101** | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 28,500,000.00 | 3,000,000.00 |
| **131104** | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,944,527.00 | 1,630,293.00 |
| **131105** | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 490,000.00 | 403,900.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 773,884,400.00 | 1,306,027,600.00 |
| **132001** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 773,884,400.00 | 1,306,027,600.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,139,463,192.35** | **1,518,175,100.60** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,139,463,192.35** | **1,490,175,100.60** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,103,040,837.58 | 1,385,275,074.53 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 366,855,041.09 | 664,183,815.51 |
| **210101** | Үндсэн цалин | 214,822,197.09 | 328,127,872.51 |
| **210102** | Нэмэгдэл | 98,123,984.00 | 224,098,773.00 |
| **210103** | Унаа хоолны хөнгөлөлт | 10,167,000.00 | 21,085,000.00 |
| **210104** | Урамшуулал | 43,741,860.00 | 28,001,050.00 |
| **210105** | Гэрээт ажлын хөлс | - | 62,871,120.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 45,091,219.07 | 82,314,418.22 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 31,188,580.35 | 55,003,902.92 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 3,609,164.69 | 6,998,199.83 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 2,670,216.51 | 3,499,200.00 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 684,958.22 | 3,458,108.14 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 6,938,299.30 | 13,355,007.33 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 28,432,238.31 | 29,562,684.07 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 11,890,536.93 | 14,057,084.07 |
| **210302** | Түлш, халаалт | 16,541,701.38 | 13,705,600.00 |
| **210303** | Цэвэр, бохир ус | - | 1,800,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 44,506,059.00 | 46,261,023.00 |
| **210401** | Бичиг хэрэг | 5,482,400.00 | 4,475,230.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 31,099,259.00 | 34,411,793.00 |
| **210403** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,805,600.00 | 4,472,100.00 |
| **210405** | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 1,000,000.00 |
| **210406** | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,118,800.00 | 1,579,400.00 |
| **210407** | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 322,500.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 4,828,900.00 | 1,657,100.00 |
| **210502** | Хоол, хүнс | 3,458,900.00 | - |
| **210503** | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,370,000.00 | 1,657,100.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 61,164,600.00 | 25,254,300.00 |
| **210601** | Багаж, техник, хэрэгсэл | 250,000.00 | - |
| **210603** | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,125,600.00 | 1,423,100.00 |
| **210604** | Урсгал засвар | 59,789,000.00 | 23,831,200.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 16,906,000.00 | 18,472,000.00 |
| **210702** | Дотоод албан томилолт | 16,906,000.00 | 18,472,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 136,718,996.51 | 96,814,909.00 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 133,864,109.51 | 89,652,434.00 |
| **210802** | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 588,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **210803** | Даатгалын үйлчилгээ | 617,625.00 | 620,000.00 |
| **210804** | Тээврийн хэрэгслийн татвар | 613,786.00 | 560,780.00 |
| **210805** | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 242,000.00 | 245,000.00 |
| **210806** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | 3,185,000.00 |
| **210807** | Газрын төлбөр | 931,476.00 | 1,963,695.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 398,537,783.60 | 420,754,824.73 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 69,965,863.00 | 105,922,000.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,471,050.00 | 1,966,330.00 |
| **210903** | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 327,100,870.60 | 312,866,494.73 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 36,422,354.77 | 104,900,026.07 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,302,000.00 | 47,550,944.00 |
| **213208** | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 35,682,944.00 |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,302,000.00 | 11,868,000.00 |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 28,120,354.77 | 57,349,082.07 |
| **213303** | Төвлөрүүлэх шилжүүлэг | 28,120,354.77 | 57,349,082.07 |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **28,000,000.00** |
| 2200 | **Дотоод эх үүсвэрээр** | - | 28,000,000.00 |
| **223001** | Бусад хөрөнгө | - | 28,000,000.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(52,786,265.35)** | **3,816,120,713.40** |
| 225 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 6,758,787.76 | - |
| **225001** | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 6,758,787.76 | - |
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (6,758,787.76) | - |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(59,545,053.11)** | **3,816,120,713.40** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **829,018,927.00** | **1,316,061,793.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,200,000.00** | **5,000,000.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 3,200,000.00 | 5,000,000.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 200,000.00 | - |
| **1200042** | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 200,000.00 | - |
| **120009** | Бусад орлого | 3,000,000.00 | 5,000,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **825,818,927.00** | **1,311,061,793.00** |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 51,934,527.00 | 5,034,193.00 |
| **131101** | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 28,500,000.00 | 3,000,000.00 |
| **131104** | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,944,527.00 | 1,630,293.00 |
| **131105** | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 490,000.00 | 403,900.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 773,884,400.00 | 1,306,027,600.00 |
| **132001** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 773,884,400.00 | 1,306,027,600.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **763,825,902.00** | **1,265,462,993.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **763,825,902.00** | **1,265,462,993.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **728,098,547.23** | **1,160,562,966.93** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 366,200,891.69 | 662,606,296.00 |
| **210101** | Үндсэн цалин | 205,639,249.47 | 301,964,528.00 |
| **210102** | Нэмэгдэл | 109,466,724.22 | 242,508,650.00 |
| **210103** | Унаа хоолны хөнгөлөлт | 11,921,486.00 | 28,807,865.00 |
| **210104** | Урамшуулал | 39,173,432.00 | 27,274,730.00 |
| **210105** | Гэрээт ажлын хөлс | - | 62,050,523.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,454,800.00 | 83,743,454.86 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 31,957,600.65 | 56,392,674.05 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 3,738,661.54 | 6,998,199.83 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 2,998,134.93 | 3,499,200.00 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 743,300.00 | 3,458,108.14 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 7,017,102.88 | 13,395,272.84 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,054,738.31 | 32,729,284.07 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 13,987,488.31 | 14,057,084.07 |
| **210302** | Түлш, халаалт | 13,067,250.00 | 16,872,200.00 |
| **210303** | Цэвэр, бохир ус | - | 1,800,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 32,424,766.00 | 45,646,393.00 |
| **210401** | Бичиг хэрэг | 3,930,000.00 | 4,200,000.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 22,085,766.00 | 33,167,193.00 |
| **210403** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,995,600.00 | 4,472,100.00 |
| **210405** | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 1,000,000.00 |
| **210406** | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,413,400.00 | 2,807,100.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 2,084,400.00 | 1,807,100.00 |
| **210503** | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,084,400.00 | 1,807,100.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 37,521,600.00 | 58,359,700.00 |
| **210601** | Багаж, техник, хэрэгсэл | 4,802,000.00 | 25,455,500.00 |
| **210603** | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,607,600.00 | 1,943,100.00 |
| **210604** | Урсгал засвар | 31,112,000.00 | 30,961,100.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 16,434,000.00 | 18,472,000.00 |
| **210702** | Дотоод албан томилолт | 16,434,000.00 | 18,472,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 136,244,423.23 | 128,705,159.00 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 133,389,536.23 | 121,546,234.00 |
| **210802** | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 588,000.00 |
| **210803** | Даатгалын үйлчилгээ | 903,911.00 | 620,000.00 |
| **210804** | Тээврийн хэрэгслийн татвар | 397,800.00 | 560,780.00 |
| **210805** | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 171,700.00 | 245,000.00 |
| **210806** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | 3,185,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **210807** | Газрын төлбөр | 931,476.00 | 1,960,145.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 63,678,928.00 | 128,493,580.00 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 60,909,878.00 | 125,497,050.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,769,050.00 | 2,996,530.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **35,727,354.77** | **104,900,026.07** |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,607,000.00 | 47,550,944.00 |
| **213208** | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 35,682,944.00 |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,607,000.00 | 11,868,000.00 |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 28,120,354.77 | 57,349,082.07 |
| **213303** | Төвлөрүүлэх шилжүүлэг | 28,120,354.77 | 57,349,082.07 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **65,193,025.00** | **50,598,800.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **66,243,025.00** | **50,500,000.00** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **66,243,025.00** | **50,500,000.00** |
| 2200 | **Дотоод эх үүсвэрээр** | 66,243,025.00 | 50,500,000.00 |
| **223001** | Бусад хөрөнгө | 66,243,025.00 | 50,500,000.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(66,243,025.00)** | **(50,500,000.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (1,050,000.00) | 98,800.00 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 1,084,800.00 | 34,800.00 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 34,800.00 | 133,600.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,601,661,368.17 | 51,130,478.64 | 1,419,765,949.90 | 3,072,557,796.71 |
| **C02** | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 7,611,486.00 | 7,611,486.00 |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,601,661,368.17** | **51,130,478.64** | **1,427,377,435.90** | **3,080,169,282.71** |
| **C04** | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | (7,611,486.00) | - | (7,611,486.00) |
| **C07** | Тайлант үеийн үр дүн | - | - | (59,545,053.11) | (59,545,053.11) |
| **C08** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,601,661,368.17** | **43,518,992.64** | **1,367,832,382.79** | **3,013,012,743.60** |
| **D01** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,601,661,368.17** | **43,518,992.64** | **1,367,832,382.79** | **3,013,012,743.60** |
| **D02** | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,601,661,368.17** | **43,518,992.64** | **1,367,832,382.79** | **3,013,012,743.60** |
| **D08** | Тайлант үеийн үр дүн | - | - | 3,816,120,713.40 | 3,816,120,713.40 |
| **D09** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,601,661,368.17** | **43,518,992.64** | **5,183,953,096.19** | **6,829,133,457.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,306,327,600.00 | 1,248,678,517.93 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,255,827,600.00 | 1,198,178,517.93 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,208,624,100.00 | 1,151,027,573.93 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 699,821,000.00 | 662,606,296.00 |
| **210101** | Үндсэн цалин | 296,989,400.00 | 301,964,528.00 |
| **210102** | Нэмэгдэл | 246,325,000.00 | 242,508,650.00 |
| **210103** | Унаа хоолны хөнгөлөлт | 28,930,000.00 | 28,807,865.00 |
| **210104** | Урамшуулал | 44,110,200.00 | 27,274,730.00 |
| **210105** | Гэрээт ажлын хөлс | 83,466,400.00 | 62,050,523.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 87,477,500.00 | 83,743,454.86 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 59,484,500.00 | 56,392,674.05 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 6,998,200.00 | 6,998,199.83 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 3,499,200.00 | 3,499,200.00 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 3,499,200.00 | 3,458,108.14 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 13,996,400.00 | 13,395,272.84 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32,822,500.00 | 32,729,284.07 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 14,098,500.00 | 14,057,084.07 |
| **210302** | Түлш, халаалт | 16,924,000.00 | 16,872,200.00 |
| **210303** | Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 42,530,300.00 | 42,479,200.00 |
| **210401** | Бичиг хэрэг | 4,200,000.00 | 4,200,000.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| **210403** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,478,200.00 | 4,472,100.00 |
| **210405** | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,045,000.00 | 1,000,000.00 |
| **210406** | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,807,100.00 | 2,807,100.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 1,807,100.00 | 1,807,100.00 |
| **210503** | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,807,100.00 | 1,807,100.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 58,365,000.00 | 58,359,700.00 |
| **210601** | Багаж, техник, хэрэгсэл | 25,460,800.00 | 25,455,500.00 |
| **210603** | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,943,100.00 | 1,943,100.00 |
| **210604** | Урсгал засвар | 30,961,100.00 | 30,961,100.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 19,500,000.00 | 18,472,000.00 |
| **210702** | Дотоод албан томилолт | 19,500,000.00 | 18,472,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 139,700,700.00 | 127,238,159.00 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 129,895,000.00 | 120,079,234.00 |
| **210802** | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 622,800.00 | 588,000.00 |
| **210803** | Даатгалын үйлчилгээ | 620,000.00 | 620,000.00 |
| **210804** | Тээврийн хэрэгслийн татвар | 614,000.00 | 560,780.00 |
| **210805** | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 245,000.00 | 245,000.00 |
| **210806** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,740,400.00 | 3,185,000.00 |
| **210807** | Газрын төлбөр | 1,963,500.00 | 1,960,145.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 126,600,000.00 | 123,592,380.00 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 123,600,000.00 | 120,595,850.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,000,000.00 | 2,996,530.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 47,203,500.00 | 47,150,944.00 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 47,203,500.00 | 47,150,944.00 |
| **213208** | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 35,722,000.00 | 35,682,944.00 |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,481,500.00 | 11,468,000.00 |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **50,500,000.00** | **50,500,000.00** |
| 2200 | **Дотоод эх үүсвэрээр** | 50,500,000.00 | 50,500,000.00 |
| **223001** | Бусад хөрөнгө | 50,500,000.00 | 50,500,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,306,327,600.00 | 1,248,678,517.93 |
| 1320 | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,306,027,600.00 | 1,248,678,517.93 |
| **132001** | Орон нутгийн төсвөөс | 1,306,027,600.00 | 1,248,678,517.93 |
| 120004 | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 300,000.00 | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,034,193.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,034,193.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,634,193.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 3,167,193.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 3,167,193.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,467,000.00 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,467,000.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 400,000.00 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 400,000.00 |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 5,034,193.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,034,193.00 |
| **131101** | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,000,000.00 |
| **131104** | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,630,293.00 |
| **131105** | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 403,900.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 90,604.0 мянган төгрөгийн 3 алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийв. Үүнд:

1. Зураг төсөв гаргуулах гэрээний дагуу шилжүүлсэн 4,000.0 мянган төгрөгийн урьдчилгааг санхүүгийн тайланд урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй зардалд хаасан
2. ЗД-ын нөөц хөрөнгөөс Соёлын төвд олгохоор худалдаж авсан 7,500.0 мянган төгрөгийн морин хуурыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн;
3. Санхүүгийн тайланд тайлант оны элэгдлийн зардлыг 79,104.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн

Аудитаар нийт 10,162.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

### 5.1 Төлбөрийн акт

1. Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчдад олгосон мөнгөн урамшууллаас 2,835.6 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй;
2. Төрийн захиргааны албан тушаалд томилогдон тасралтгүй ажилласан хугацаа нь 5 жил хүрээгүй 1 албан хаагчид 7,326.7 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон;

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| УТЗ-ын бүртгээгүй | 1 | 7,500.0 | | | 1 | 7,500.0 | 1 | 7,500.0 | | | | |
| Хөрөнгийн ангилал зөрүүтэй | 1 | 4,000.0 | | | 1 | 4,000.0 | 1 | 4,000.0 | | | | |
| ҮХ-ийн элэгдэл зөрүүтэй | 1 | 79,104.0 | | | 1 | 79,104.0 | 1 | 79,104.0 | | | | |
| Дүн | **3** | **90,604.0** | | | **3** | **90,604.0** | **3** | **90,604.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалин зөрүүтэй олгосон | 1 | 7,326.7 | 1 | 7,326.7 | | | | | | | | |
| Хууль тогтоомжийн хэрэгжилт | 1 | 2,835.6 | 1 | 2,835.6 | | | | | | | | |
| **Дүн** | **2** | **10,162.3** | **2** | **10,162.3** | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| **Зөрчилгүй** | 0 | 0 | | | | | | |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| **Зөрчилгүй** | 0 | 0 | | | | | | |

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2025 оны 02 сарын 21 өдөр Дугаар 84-ХЭА-2025/047/ДА-СТА-ТШЗ Чингис хот
А2390049

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн захиргааны албан тушаалд томилогдон тасралтгүй ажилласан хугацаа нь 5 жил хүрээгүй 1 албан хаагчид 7,326.7 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ы өдрийн 83 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.1-д "Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан албан тушаалд томилогдон тасралтгүй 5 жил (60 сар), түүнээс дээш хугацаагаар ажилласан төрийн захиргааны албан хаагч мөнгөн урамшуулал авна" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндэслэлгүй олгосон мөнгөн урамшууллын 7,326.7 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Цэнхэрмандал сумын Засаг даргын тамгын газрын дарга Ү.Ичинхорлоо, нягтлан бодогч Б.Буяндэлгэр нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Х.ЕРКЕГҮЛ

232505084

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2025 оны 02 сарын 21 өдөр Дугаар 86-ХЭА-2025/047/НА-СТА-ТШЗ Чингис хот
А 2390049

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас 2,835.6 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.4-т “Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй татварын 2,835.6 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Цэнхэрмандал сумын Засаг даргын тамгын газрын дарга Ү.Ичинхорлоо, нягтлан бодогч Б.Буяндэлгэр нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Х.ЕРКЕГҮЛ

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112

23250508б